

МАН-ын 28-р их хурал хоёр хоног сүр дуулиантайгаар СТО-нд болж онгорлоо. Цэнгээний газарт орж буй мэт бугуйвч, мандат сэтгүүлчдэд огсон ч, сэтгүүлчдийг нохойн голог шиг хоож, хаалттай хаалганы цаана холдоох шахав. Хэвлэл мэдээллийн ажилчдыг хоож туусныг эс тооцвол Торийн тусгай хамгаалалт, цагдаа нараар хамгаалуулаад, зохион байгуулалт сайтай, хэрвэл, талцал багатай СҮРТЭЙ хуралдсан. Хурлаар хэд хэдэн асуудлыг ярилцсан. Эдгээр гол асуудал нь эмэгтэйчүүдийн квотыг нэмэгдүүлж 30 хувь болгох тухай байв. Тодруулбал МАН-ын Ү Бага хурлын гишүүдийн тоог нэмж 369 болгож, үүний 30 хувь нь эмэгтэйчүүд, 30 хувь нь намын анхан шатны байгууллагаас бүрдүүлэхээр толовлосон байна.

Намын даргаар хэнийг сонгохоо хэлэлцэв. Ү УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярвааг, УИХ-ын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж Еронхий сайд У.Хүрэлсүхийг тус тус нэр дэвшүүллээ. Мон танхимаас Архангай аймгаас сонгогдсон толоологч н.Хүрэлбаатар УИХ-ын гишүүн Ж.Монхбатыг нэр дэвшүүлсэн ч тэрбээр намын даргын орсолдооноос нэрээ татаж буйгаа мэдэгдсэн юм. Харин намын гишүүн Н.Дэмбэрэл үг хэлэхдээ намын даргад нэр дэвшихээс татгалзаж буйгаа илэрхийлэн нэрээ татав. Ингэснээр Монгол Ардын Намын даргад Еронхий сайд У.Хүрэлсүх, УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваа нар орсолдсон.

Тэдний хэнийг нь МАН-ын дарга болгох эсэхийг Ү 21 аймаг 9 дүүргээс ирсэн 1383 толоологчийн Ү 1261 нь Ү хаалттайгаар саналаа огч сонгосон юм.

Ү Монгол Улсын Еронхий сайд Ухнаагийн Хүрэлсүх 1261 толоологчийн 63.1 хувийн санал авч Монгол Ардын Намын даргаар сонгогдлоо. Ингэснээр тэрбээр Монголын улс торийн ууган хүчин МАН-ын 15 дахь даргаар сонгогдов.

Намын даргын тамгаа М.Энхболдоос албан ёсоор авсан У.Хүрэлсүх очигдроос МАН-ын хагарал, хямрал дуусч байгааг зарлав. Энэ тухайд түүний хэлсэн үг нь “Би намынхаа эв нэгдлийг нүдний цоцгий мэт хайрлан хамгаалах болно. Улс орныхоо эдийн засгийн уналтыг зогсоож, сэргээх хариуцлагатай үүрэг надад ногдож байна. УИХ дахь намын бүлгийн 33,32 гэсэн яриа энэ цаг мочоос эхлэн эцэс болж байгааг та бүхэндээ зарлая. Ийм үүрэг даалгаврыг Их хурлаас надад, МАН-ын 65 гишүүнд оглоо” Ү гэж мэдэгдсэн юм.



МАН-ын ХХҮШ их хурал сүржин, даржин ...

Бичсэн туруу

2017 оны 11-р сарын 22, Лхагва гариг, 21:46

~~МАН-ын ХХҮШ их хурал сүржин, даржин ...~~